



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар A/56

Мөрөн сум

Чанарын багууд байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.2.4, 5.4.15 дахь заалт, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5.4.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.15 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн үйлчилгээний үйл ажиллагаанд Олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх Удирдлагын дүн шинжилгээний багийг нэгдүгээр, Чанарын багийг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.
2. Аймгийн Засаг даргын Тамгын газарт 7 хоног бүрийн Пүрэв гарагийг чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх өдөр болгон, тус өдрөөр чанарын багууд үйл ажиллагаа идэвхтэй зохион байгуулсугай.
3. Аймгийн Засаг даргын Тамгын газарт Олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар ханган, холбогдох зардлыг шийдвэрлэн, стандартыг баталгаажуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг Чанарын багийн ахлагч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн A/125 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА /П.ЛХАГВАЖАВ/  
П.ЛХАГВАЖАВ

671?010177

Захирамж2024

Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын 08.ны өдрийн дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

УДИРДЛАГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

**Багийн ахлагч:**

Засаг даргын Тамгын газрын дарга

**Багийн гишүүд:**

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга


Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Цэргийн штабын дарга

Нийтлэг үйлчилгээний албаны дарга

**Нарийн бичгийн дарга:**

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын  дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

## ЧАНАРЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга  
ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ БАГ

Ахлагч:

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Багийн гишүүд:

- Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, өргөдөл гомдлын шийдвэрлэлт хариуцсан мэргэжилтэн
- Нийгэм, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн
- Авлигын эсрэг үйл ажиллагаа, ил тод байдал, хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн
- Аймгийн ерөнхий архитектор
- Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн
- Эрүүл мэндийн бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн
- Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер
- Бичиг хэргийн эрхлэгч
- Архивын тасгийн сан хөмрөгийн эрхлэгч
- Мэдээлэл технологи дотоод сүлжэээ хариуцсан ажилтан

## СУРГАЛТ ХӨГЖИЛ, ИДЭВХЖҮҮЛЭЛТИЙН БАГ

Ахлагч:

-Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Багийн гишүүд:

- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Нийтлэг үйлчилгээний албаны дарга
- Архивын тасгийн дарга
- Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн
- Агентлаг, сумдын бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
- Эрх зүйн сургалт сурталчилгаа, хууль тогтоомжийн сан, хүний эрхийн бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн
- Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, орон нутгийн өмч, жижиг, дунд үйлдвэрлэл, хоршооны бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн
- Агентлаг байгууллагын үйл ажиллагаа зохион байгуулах мэргэжилтэн
- Эрчим хүчний хяналтын улсын байгцаагч
- Засаг даргын туслах
- Нярав

## ДОТООД АУДИТЫН БАГ

Ахлагч:

-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Багийн гишүүд:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
- Сум, багийн бодлого үйл ажиллагаа, дотоод хяналтыг зохион байгуулах ахлах мэргэжилтэн
- Орон нутгийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
- Төрийн сангийн төлбөр тооцоо, төсвийн ил тод байдлыг хариуцсан мэргэжилтэн
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн

\_\_\_\_\_ооо\_\_\_\_\_